

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
 БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
 ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ
 АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ АЛБАН ТУШААЛЫН
 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилга байгууламжийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтнийг сонгон шалгаруулах зарыг олон нийтэд мэдээлж байна.

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

Нэг. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх иргэнд тавигдах болзол

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх.

Хоёр. Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1. Ерөнхий шаардлага:	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		<i>Боловсрол</i>	Дээд боловсролын бакалавр зэрэгтэй	Магистр зэрэгтэй
		<i>Мэргэжил</i>	Барилгын инженер, Барилгын талбайн даамал	Төрийн удирдлага, удирдахуйн ухаанаар мэргэшсэн байх
		<i>Мэргэшил</i>	Мэргэшсэн инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйгаар мэргэшсэн байх.	
		<i>Туршлага</i>	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.	Мэргэжлээрээ ажилласан байх

		Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Багаар ажиллах, оновчтой шийдвэр гаргах. • Манлайлах, төлөвлөх, зохион байгуулах, хянан зохицуулах чадвартай байх. • Хэл бичгийн дүрэм, найруулга, албан хэрэг хөтлөлтийн стандартын мэдлэг, ур чадвартай байх. • Хуулийн төсөл, шийдвэрийн баримт бичиг боловсруулах хууль, эрх зүйн мэдлэгтэй байх. • Эрхэлсэн ажлын чиглэлээр шийдвэрийн төсөл боловсруулах чадвартай байх. • Удирдан зохион байгуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвартай байх. • Ажлын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэгдсэн аливаа санал, шүүмжлэлийг хүлээн авах. • Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх. • Компютерийн өргөн хэрэглээний програм, нээлттэй эхийн системийг ашиглах, дотоод гадаад сүлжээнээс мэдээлэл авч, илгээх, орчин үеийн дэвшилтэт /smart/ технологийг ашиглах, нэвтрүүлэх чадвартай байх. 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Хариуцлагатай. <input type="checkbox"/> Хувийн зохион байгуулалттай. <input type="checkbox"/> Харилцааны өндөр соёлтой бусдыг хүндэтгэх. <input type="checkbox"/> Хууль, дүрэм, журмыг чанд баримталдаг.
	1.2. Тусгай шаардлага		<ul style="list-style-type: none"> • Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг чанд сахих. • Ямар ч төвшний албан бичиг баримтыг монгол хэлээр оновчтой зөв найруулан бичиж боловсруулах. • Ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. • Төр, байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалах. 	Ажлын ачааллаас шалтгаалан илүү цагаар ажиллах боломжтой байх.

Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

Уг ажлын байрны сонгон шалгаруулалтад тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид, холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа болон төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэд бүртгүүлэх боломжтой бөгөөд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.3-т заасан дарааллын дагуу нөхнө. *(Тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид бүртгүүлээгүй тохиолдолд холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа болон төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс сонгон шалгаруулна. Тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид бүртгүүлсэн тохиолдолд холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа болон төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс оролцох боломжгүй болохыг анхаарна уу.)*

- Төрийн албан хаагчийн анкет “А хэсэг” болон “Б хэсэг”;
- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Иргэний үнэмлэхний хуулбар, эх хувийн хамт;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн хуулбар, эх хувийн хамт; /Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/;
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, эх хувийн хамт; /албан тушаалын тодорхойлолтын туршлагын шаардлагад заасны дагуу дэс түшмэлийн ангилалд ажилласныг нотлох тушаал, шийдвэрийг холбогдох байгууллагаас хуулбарлан авч ирэх бөгөөд байгууллагын “Хуулбар үнэн” даруулж хавсаргах/;
- “4 х 6”-гийн хэмжээний 2 хувь цээж зураг;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт;

Дээр заасан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн, зохих ёсоор бүрдүүлээгүй иргэнийг бүртгэхгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх

Сонгон шалгаруулалтад оролцох төрийн жинхэнэ албан хаагчийн хүсэлт болон бүрдүүлсэн баримт бичгийг Барилга, хот байгуулалтын яамны 318 тоотод /Хаяг: Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын XII байр, 3 давхар/ 2019 оны 06 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд комисс хүлээн авна.

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх болзлыг хангаж, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн албан хаагчийг бүртгэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа гаргах бөгөөд болзол хангаагүй бол энэ тухай шалтгааныг мэдэгдэнэ.

Тав. Сонгон шалгаруулалтын хуваарь

Сонгон шалгаруулалтыг 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 14:00 цагт дараахь агуулгын хүрээнд зохион байгуулна. Үүнд:

1. Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;
2. Дүн шинжилгээ хийх чадвар;
3. Асуудал шийдвэрлэх чадвар;
4. Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар;
5. Багаар ажиллах чадвар.

Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцох иргэн “Иргэний цахим үнэмлэх” биедээ авч ирэхийг анхаарна уу.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ

Холбоо барих утас: 76003333-1124